Орон бүхний пролетари нар нэгдэгтүн!

# Анхдугаар ТАВАН ЖИЛ

ТӨВ АЙМГИЙН НАМЫН ХОРОО, А Д. Х. Г. ЗАХИРГААНЫ СОНИН

17 дахь жилдээ
№ 37 (1372)

1964 оны
5 дугаар сарын 7

ПҮРЭВ

## Их хурлаа өрнүүн амжилтаар угтаж, бага хурлынхаа шийдвэрийг биелүүлье

Манай нам, засгаас эх орны соёл, шинжлэх ухаан, хөдөлмөрийн асар их хүч болсон эмэгтэйчүүдийн соёл хүмүүжлийн ажилд цаг дутам анхаарал тавьж, зүйл бүрийн бодит арга хэмжээ авсаар байна.

Энэ нь манай хөдөлмөрчин эмэгтэйчүүдийн улс төр, хөдөлмөрийн идэвхийг хязгааргүй их өрнүүлэх хүчин зүйл нь болж, тэдний дундаас хөдөлмөрийн баатарууд, эрдэмтэд, зохиолчид, нам, төр, олон нийт, соёл урлагийн нэрт зүтгэлтнүүдийг төрүүлсээр байна.

БНМАУ-ын социализмын байгуулалтын их үйлст манай эмэгтэйчүүдээс гар бие оролцоогүйгээр бүтээгдсэн өчүүхэн ч зүйлгүй гэхэд л бүрэн хүрэлцээтэй юм. МАХН—ын Төв Хорооноос эмэгтэйчүүдийн дунд зохиох соёл хүмүүжлийн ажлын эрч далайцыг улам сайжруулж тэдний бүтээлч ажиллагааг эрс өрнүүлэх зорилгоор монголын эмэгтэйчүүдийн 4 дүгээр их хурлыг энэ оны 6 дугаар сард хуралдуулахаар заасан заалт нь тус аймгийн хөдөлмөрчин эмэгтэйчүүдийг их өрнөлтөд дуудсан уриа болжээ. Аймгийн мал аж ахуй, худалдаа бэлтгэлийн үйлдвэрлэлд ажилладаг хүмүүсийн 78,8 хувь эзэлж байгаа эмэгтэйчүүд уран авхаалжит ажиллагаагаараа аймгийн малын төл бойжилтын 92,7 хувийг, хөөвөр, хялгас, ноолуурын төлөвлөгөөний 102—104 хувийг гагцхүү эмэгтэйчүүд биелүүлээд байна. Монголын эмэгтэйчүүдийн их хурал угтсан хөдөлмөр соёлын чуулгантөв, хөдөөг хамарсаны дотор Баян, Баянжаргалан, Мөнгөнморьт, Эрдэнэ, Эрдэнэсант, сумдад их өрнөлттэй явагдаж байна. Үйлдвэр, барилга, соёл гэгээрлийн байгууллагуудад их хурал угтсан ажил эрчимтэй өрнөж байна.

Энэ 5 дугаар сарын 7-нд аймгийн эмэгтэйчүүдийн 6 дугаар бага хурал аймгийн төвд болж аймгийн эмэгтэйчүүдийн зөвлөлийн дарга нөхөр Д.Дашпунцаг «Эмэгтэйчүүдийн дунд зохиож байгаа соёл хүмүүжлийн ажил, цаашид тавих зорилт» гэсэн илтгэл тавьж хэлэлцүүлэв.

Тус бага хуралд төв, хөдөөгийн зөвлөлүүдээс өөрсдийн мэдлэг хүмүүжлээ цуцалтгүй дээшлүүлж, ажлаараа товойн шалгаран сонгогдсон 39 төлөөлөгчдөөс гадна, аймгийн намын хорооны товчоо, АДХ-ын Гүйцэтгэх Захиргааны гишүүд, төвийн албан байгууллагын дарга нар оролцож, аймгийн эмэгтэйчүүдийн байгууллагын ажилд дүн шинжилгээ хийв.

Бага хурал: Намын байгууллагаас эмэгтэйчүүдийн дунд зохиох ажлыг удирдах удирдлага сайжирсан, аймгийн эмэгтэйчүүдийн дунд БНМАУ—ын Ардын Их Хурлын депутатууд, хөдөлмөрийн баатарууд, аймаг сум, хороодын хурлын депутатууд олон арав ажиллаж байгаа зэрэг нь эмэгтэйчүүдийн байгууллагын нэр хүндийг дээшлүүлэх, ажил нь тогтмолжих, тэргүүний хүмүүс, аймаг, сумдын аврагчуудын тоог олшруулах үндэс нь болж байна гэж дүгнэв.

Үүний зэрэгцээгээр аймгийн эмэгтэйчүүдийн зөвлөлийн тэргүүлэгчид, үндсэн зөвлөлүүдийн ажилд хангалтгүй тусалдаг намын анхан шатны нилээд байгууллага тодорхой удирдлагаар хангадаггүй, залуучууд, үйлдвэрчний эвлэлийн үүр, хороод, эмэгтэйчүүдийн байгууллагуудтай ажлаа хамтран явуулах ажил сул, олонх зөвлөл ажил санаачлах талаар мохоо байгаа зэрэг дутагдлыг бага хурал хурц шүүмжлэв.

Бага хурлын явцад, аймгийн намын хорооны товчоо, АДХ—ын Гүйцэтгэх Захиргааны гишүүд, бага хурлын төлөөлөгчид, үндсэн зөвлөлийн дарга нарыг хүлээн авч эрэлт хүсэлтий нь сонсож, тодорхой зөвлөлгөөн өгсөн нь бага хурлаас гарах шийдвэрийг улам баяжуулав.

6 дугаар бага хурал, шинэ хүмүүсийн эх, шимт малын эзэд аймгийн эмэгтэйчүүдийн өмнө том зорилт дэвшүүлэв.

Юуны урьд социалист хөдөлмөрийн бригадын хөдөлгөөнийг удирдан өрнүүлэх, өөрсдөө тэргүүн эгнээнд оролцох, гэрийн ясли, цэцэрлэгийг Батсүмбэрийн сангийн аж ахуйн жишээгээр байгуулах, асрагч, хүмүүжүүлэгчдэд хамгийн шилдэг хүмүүс тавих, ном их унших, мэдлэг, ажлын арга дадлагаа баяжуулах, тэргүүний хүмүүсээ сурталчлах, тэдний жишээгээр ажиллах нь онц чухал болов.

Зөвлөлтийн мэргэжилтнүүдийн гэр бүлээс их сурч, гэр ахуйн соёлжилтыг үлгэр жишээч болгох, урлагт биечлэн оролцож кино их үзэх, концерт, жүжиг зохион байгуулах, гэр бүлийн гимнастикийн хөдөлгөөн газар бүр өрнүүлэх нь онцгой ач холбогдолтой юм.

Өөрсдийн эрхтэй холбогдсон хууль, тогтоолуудыг хүн бүрд ухуулгын олон хэлбэр ашиглан сайн мэдрүүлэх, түүвэрлэн авч ашиглуулах нь, зарим газар эмэгтэйчүүдийн хөдөлмөр дарагдаж байгаа, гэр бүлийн тогтвор алдах, зарим талаар эмэгтэйчүүдийн эрхийг хүндэтгэхгүй үзэгдэлтэй тэмцэх үндэс нь болох ёстой.

Манай эмэгтэйчүүд үр хүүхдээ зөв хүмүүжүүлэх, соёл урлаг, эмнэлэг, эмийн ба номын сан, худалдаа, нийтийн хоолны зэрэг бүх үйлчилгээний ажил голлон хийдэг учир тэдгээрийн ажлыг эрс сайжруулах үүрэгтэй.

Тус бага хурал, аймгийн эмэгтэйчүүдийн бүгд хурлыг 30, зөвлөлийн тэргүүлэгчдийг 9 хүний бүрэлдэхүүнтэй сонгож, монголын эмэгтэйчүүдийн 4 дүгээр их хуралд нам, захиргаа, олон нийтийн ажилтан, багш, эмч, саальчин, ногоочин, тракторч, нормчин, барилгачин, худалдагч, анчин зэрэг хөдөлмөрөөрөө шалгарсан 29 хүн сонгов.

Их хурлаа ирмүүн амжилтаар угтаж, бага хурлынхаа шийдвэрийг ширхэгчлэн биелүүлэх ажил тус аймгийн эмэгтэйчүүдийн одоогийн эрхэм зорилт мөн.

## Аймгийн АДХ-ын Гүйцэтгэх Захиргаанд

### Аймгийн чуулганыг хуралдуулах тухай

Аймгийн АДХ-ын Гүйцэтгэх Захиргааны гишүүдийн хуралдаанаар АДХ-ын ээлжит чуулган хуралдуулах тогтоол гаргав.

Аймгийн АДХ--ын 6 дахь удаагийн 5 дугаар чуулганыг 1964 оны 6 дугаар сарын 18-ны өдөр хуралдуулж:

а) Мал өсгөх улсын төлөвлөгөөний биелэлтийн явцын тухай, Баянчандмань, Баяндэлгэр сумдын АДХ-ын Гүйцэтгэх Захиргаадын илтгэл.

б) Ноос бэлтгэлийн явцын тухай, худалдаа бэлтгэлийг удирдах газрын илтгэл.

в) Хөдөө аж ахуйн байнгын комиссын тайлан илтгэл тус тус хэлэлцүүлэхээр тогтоожээ.

## АЛТАН ХАЙРЦАГ ХЭН НЭЭВ

Өндөрширээт сумын хаврын тариалалтанд ажиллаж байгаа Эрдэнэсантын МААМС—ын Сономжамц ахлагчтай байнгын салаа өндөр бүтээлийн 10 хоногийн ажил зохиож ажиллав.

Өндөр бүтээлийн 10 хоногт «ДТ—54» трактораар 233 га үрлэж, 28 га хагалсан салааны ахлагч Сономжамц сум—нэгдлийн ерөнхий хорооноос хаврын тариалалтын талаар зарласан «Алтан хайрцаг» нээх болзлыг хангаж уг хайрцгийг нээв.

*Ш. Санжмятав*

## Ноос бэлтгэлийн явц

**Тус аймгийн хөдөлмөрчид 1963 онд ноос бэлтгэх талаар олсон амжилтаа 1964 онд үргэлжлүүлж 100 хувьтай сумын тоо урьд оны энэ үеэс ноосны төрөл бүр дээр нэмэгдсэн. Бодын хөөвөр хялгас бэлтгэсэн хэмжээ урьд оноос 2,8-4,7 хувиар өссөн байна.**

**Ноос бэлтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 5 дугаар сарын 1—ний байдлаар хувиар үзүүлвэл:**

| дугаар | сумд | бодын хөөвөр | бодын хялгас | тэмээний ноос | ямааны ноолуур | нохойн ноолуур |
|---|---|---|---|---|---|---|
| 1. | Угтаал | 105,9 | 102,0 | 21,9 | 64,9 | 110,0 |
| 2. | Өнжүүл | 103,4 | 101,4 | 17,8 | 26,3 | = |
| 3. | Эрдэнэсант | 102,8 | 100,1 | 17,8 | 65,8 | 23,0 |
| 4. | Архуст | 102,7 | 110,3 | 50,1 | 80,3 | 100,0 |
| 5. | Тариат | 102,0 | 100,0 | 32,8 | 54,1 | 100,0 |
| 6. | Баянцогт | 101,4 | 100,7 | 36,3 | 47,3 | = |
| 7. | Баянцагаан | 101,1 | 100,0 | 11,0 | 86,4 | 100,0 |
| 8. | Өндөрширээт | 100,4 | 103,3 | 18,0 | 77,1 | = |
| 9. | Баяндэлгэр | 100,2 | 100,0 | 15,4 | 61,8 | 30,0 |
| 10. | Мөнгөнморьт | 100,1 | 100,0 | 17,4 | 25,9 | 30,0 |
| 11. | Баянчандмань | 100,0 | 103,0 | 125,0 | 45,8 | 20,0 |
| 12. | Баянбараат | 94,6 | 100,1 | 21,6 | 76,8 | 125,0 |
| 13. | Дэлгэрхаан | 94,3 | 100,3 | 17,1 | 79,8 | 106,6 |
| 14. | Лүн | 80,5 | 100,0 | 16,0 | 50,1 | 13,3 |
| 15. | Бүрэн | 77,0 | 100,4 | 27,0 | 44,0 | 100,0 |
| 16. | Заамар | 74,8 | 101,2 | 30,5 | 33,7 | 100,0 |
| 17. | Жаргалант | 70,0 | 103,5 | 109,7 | 86,8 | 40,0 |
| 18. | Борнуур | 66,9 | 100,4 | 34,2 | 36,7 | = |
| 19. | Алтанбулаг | 60,1 | 100,0 | 29,2 | 51,5 | 16,6 |
| 20. | Баян | 51,5 | 113,1 | 15,0 | 68,9 | 107,6 |
| 21. | Баянзүрх | 51,0 | 100,0 | 50,4 | 58,0 | 100,0 |
| 22. | Сэргэлэн | 50,3 | 100,0 | 35,6 | 55,6 | 106,6 |
| 23. | Батсүмбэр | 45,9 | 101,7 | 5 да | 41,5 | 122,2 |
| 24. | Эрдэнэ | 36,5 | 100,0 | 20,5 | 30,0 | 8,3 |
| 25. | Баянжаргалан | 26,3 | 100,0 | 12,0 | 53,4 | 5,0 |
| | Аймгийн дүн | 76,7 | 101,3 | 22,0 | 59,2 | 60,3 |

Статистикийн товчоо

